

2/2021


Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 13



Нас гүйцсэн эр хонины үнэ Дархан-Уул аймагт хамгийн их буюу 240.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 2 дугаар сард ат 1.1 сая төгрөг, хязаалан гуна 1.0 сая төгрөг болж, өмнөх сараас тус тус өөрчлөлтгүй, соёолон үрээ 904.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.3 мянган төгрөгөөр, эр хонь 165.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 0.5 зуун төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Харин эр ямаа 120.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 0.1 зуун төгрөгөөр буурсан байна.

Зураг 1. Нас гүйцсэн малын дундаж үнэ, 2 дугаар сард, мянган төгрөгөөр




Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 2 дугаар сард эр хонь Дархан-Уул аймагт хамгийн их буюу 240.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 27.5 мянган төгрөгөөр өссөн байна. Харин Баянхонгор аймагт хамгийн бага буюу 122.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Зураг 2. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 2 дугаар сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 2 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 8.1 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй, ямааны цагаан ноолуур кг-ын үнэ 58.6 мянган төгрөг болсон нь өмнөх сараас 0.1 зуун төгрөгөөр өссөн байна.

Зураг 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 2 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 2 дугаар сард боодолтой (20кг) өвсний үнэ Архангай аймагт хамгийн их буюу 14.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 10.0 төгрөгөөр, Дорнод аймагт хамгийн бага буюу 5.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 20.0 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Боодолтой өвсний дундаж үнэ, 2021 оны 2 дугаар сард, мянган төгрөгөөр



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 2 дугаар сард 25кг хивгийн үнэ Сүхбаатар аймагт хамгийн их буюу 26.0 мянган төгрөг, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 13.2 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

## Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Эх үүсвэр: ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ



## Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 17

*Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн  
газрын Гэрээт ажилтан Б. Оргил  
Утас : (976-51)-261561*

